

цаа ба нутаг дэвсгэрийн тэгшитгэл» (усан зам, цахилгаан, шуудан холбоо, усан хангамж, зам тээвэр ба газар нутгийн тэгшитгэл; эсвэл «7 төрлийн харилцаа ба нутаг дэвсгэрийн тэгшитгэл хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Энэ нь ЭЗОБ-ийн бүтээн байгуулалтын явцдаа олсон нааштай туршлага болов. ЭЗОБ байгуулахдаа гадаад дотоодын эрдэмтдийн саналыг хамтатган ерөнхий төлөвлөгөө боловсруулж, үүндээ төлөвлөлт, газраа тогтох, ерөнхий стандарт, газар доорх байгууламж, янз бүрийн бүс нутгийн үйлдвэрлэх хүчний байршлыг тогтоох, барилгын зураг төсөл хянах, харилцан шаардлага тавих, ногоожуулах гэсэн найман чиглэлээр нэгдсэн бодлого явуулахаар тусгажээ. Ингэснээр хөрөнгө мөнгө хэмнэх талаар сайн үр дүнд хүрсэн юм.

4. Бие даан янз бүрийн сувгаар мөнгө олж, барилга байгууламж барих явдал Хятадын ЭЗОБ-ийн нэг чухал туршлага болов. Олон орон худалдааны чөлөөт бүс, экспортын боловсруулах үйлдвэрийн бүс зэргийг байгуулахдаа улсаас хөрөнгө авдаг. Манайх ч гэсэн зарим бүс нутагт улсаас төвлөрсөн журмаар хөрөнгө гаргасан. Харин манай ЭЗОБ ийн эрэлт хэрэгцээ маш их тул улсын дэмжлэгтэйгээр орон нутгийн захиргаа, үйлдвэр, аж ахуйн газар гадаадаас хөрөнгө оруулах, банкны зээл авах, өөрсдөө хөрөнгө хуримтлуулах зэргээр шийдвэрлэхээс гадна, гадаадынханд бие даан хариуцах бүрэн эрх олгож байна. Жишээ нь: Шэньжэньд 1979 оноос 1983 онд их барилгад оруулсан хөрөнгийн 30,9 хувь нь гадаад хөрөнгө, 29,3 хувь банкны зээл байв.

Ийнхүү ЭЗОБ-д ихээхэн аз туршсан нөхцөлд хөрөнгө оруулалтын ашиглалтыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн үр ашигт улам бүр анхаарал хандуулж байна. ЭЗОБ-үүд их барилга болон бие даасан гэрээт хариуцлагын системийн хэрэгжилтээр улсдаа тэргүүлж байгаа юм. Жишээ нь, их барилга дээр 7 хоногт 1 давхар, зарим үед 3 өдөрт 1 давхрыг босгож байна. Энэ нь олон улсын төвшинд хүрч ЭЗОБ-ийн барилга байгуулалтыг түргэтгэв.

1990-ээд оны хувьд, Хятадын ЭЗОБ хөгжлийн шинэ үе шатанд орлоо. Шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлж, үйлдвэрийн бүтцээ чамбайруулж, техникийн дэвшлээ түргэтгэх юм. Мөн хөрөнгө оруулах нөхцөл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж олон улсын өрсөлдөөнд (харил цаанд) өргөн хүрээнд ул суурьтай оролцож, Хятадын онцлогтой социализм байгуулахад хувь нэмэр оруулна.

## **ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД**

**М. Нарантуяа\***

Ази тивийн Япон улс нь ХХ зууны II хагаст эдийн засгийн гайхамшгийг үзүүлсэн билээ. Японы эдийн засгийн эрчимт хөгжлийн хүчин зүйлүүд нь юу болох, тус улсын эдийн засгийн бодлогын нууц нь чухам юундаа байгааг олон орны эрдэмтэд сонирхон, нарийвчлан судалсаар байна. Японтой нэг тивд оршиж, зах зээлийн эдийн засагт шилжиж буй манай улсын хувьд энэ асуудал бүр ч сонирхолтой нь мэдээж билээ.

\*Дорно дахин олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Японы эдийн засгийн хамгийн эрчимтэй хөгжлийн суурь үе нь 1955-70-аад оны эхэн хүртэл үргэлжилсэн байна. Төрөөс эдийн засгийг төлөвлөгөөтэй хөгжүүлэхийн тулд урт хугацааны, дунд хугацааны, жилийн гэсэн хөтөлбөр зохион хэрэгжүүлж иржээ. 15-20 жилийг хамарсан урт хугацааны төлөвлөгөө нь Японы ирээдүйн дүр төрхийг урьдчилан харах, хөгжлөөр дорой районуудыг тэнцвэртэй хөгжүүлэхэд чиглэдгээрээ онцлог бөгөөд уг бодлогоо хэрэгжүүлэх тодорхой арга замыг зааж өгдөггүй байна. Харин дунд хугацааны төлөвлөгөөг 5 жилээр тогтоохдоо нийгэм-эдийн засгийн салбарт Засгийн газраас явуулах арга хэмжээг нарийвчлан тодорхойлж, тооны үзүүлэлтээр харуулдаг. Жилийн төлөвлөгөө нь төсвийн төлөвлөлт юм. Дээрх 3 хэлбэрийн төлөвлөлтөөс дунд хугацааны төлөвлөгөө нь улсын эдийн засгийн хөгжлийн хамгийн чухал программ болдог байна. 1955 онд «Эдийн засгийн бие даасан байдалд хүрэх 5 жилийн төлөвлөгөө», 1957 онд «Эдийн засгийн хөгжлийн урт хугацааны шинэ төлөвлөгөө», 1960 онд «Үндэсний орлогыг 2 дахин өсгөх төлөвлөгөө»-г тус тус боловсруулсны дотор сүүлд дурдсан төлөвлөгөөг эрчимтэй хөгжлийн үеийн эдийн засгийн бодлогын үндэс болсон гэж үздэг. Энэхүү төлөвлөгөөнд ард түмний аж байдлыг дээшлүүлэх, хүн амыг ажлын байраар бүрэн хангах, эдийн засгийн өсөлтийг тогт вортой өндөр хэмжээнд байлгах, зорилт тавьж, 10 жилийн дараа үндэсний нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2 дахин өсгөх, эдийн засгийн жилийн дундаж өсөлт 7,2 хувь байхаар төлөвлөжээ. Үүний тулд гадаад худалдааг өргөжүүлж, үйлдвэрлэлийн бүтцийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн, Нийгмийн хөрөнгө оруулалт болон санхүүгийн бодлогыг хувийн үйлдвэрийн газруудын санаачилгатай нягт хослуулах шаардлагатайг заасан байна. Мөн нийгмийн хөрөнгө оруулалтыг нарийн төлөвлөгөөтэйгөөр хуваарилж, зам, тээвэр зэрэг салбарт оруулах хөрөнгө оруулалтыг боловсронгуй болгох; хүний хүчин зүйлийг оновчтой ашиглаж, ард түмний бүтээлч санаачилгыг нээн илрүүлж, хувийн аж ахуйг хөгжүүлэх; хот, хөдөөгийн ялгааг арилгах зэрэг асуудал тусгасан байна.

Япончууд эдийн засгаа хөгжүүлэхдээ дэлхийн тэргүүний хөгжилтэй орны төвшинд хүрэх шалгуур үзүүлэлт гаргаж, түүнд хүрэх алсын хараатай, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, үүнийхээ дагуу төрөл бүрийн арга хэмжээ авдаг аж. Төлөвлөгөөт зорилт нь хугацаанаас Өмнө биелэгдсэн бол урьд социалист гэгдэж байсан орнуудын адил батлагдсан хугацааг заавал дуусгана гэхгүйгээр дараагийн зорилтоо дэвшүүлэн залгаж хэрэгжүүлдэг тул хөгжлийн нь эрчим буурдаггүй байна. Тухайлбал, 1955 оноос гараагаа авсан 5 жилийн төлөвлөгөө 1960 онд дуусах байсан боловч 1957 он гэхэд давж биелэгдсэн учир дараачийн зорилтоо мөн оноос эхлэн дэвшүүлсэн нь эдийн засгийн хөгжлийн хурдцыг улам нэмэгдүүлэх эрмэлзлийг бадраажээ.

Японы төлөвлөлтийн системийн нэг гол онцлог нь урт хугацааны төлөвлөлтийг дунд, богино хугацааныхтай чадварлаг хослуулж, аж ахуйн салбар тус бүрээр нарийн зохицуулан боловсруулдагт оршино. Тухайлбал, «Төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 2 дугаар төлөвлөгөө» (1956-1960), «Эрчим хүчийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө», «Нефть, химийн салбарыг хөгжүүлэх 1 дүгээр төлөвлөгөө» (1958-1959) зэрэг аж ахуйн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон төлөвлөгөөг удаа дараа батлан хэрэгжүүлсэн байна.

1956 онд Худалдаа, аж үйлдвэрийн яамны санаачилгаар автомашины сэлбэг хэрэгсэл, суурь машины үйлдвэрлэлд онцгой анхаарсан «Машины үйлдвэрлэлийг хөгжүүлэх яаралтай арга хэмжээний тухай» хууль баталж, автомашины үйлдвэрлэлийг эдийн засгийн эрчимтэй хөгжлийн тэргүүлэгч салбар болгон хөгжүүлэх зорилт тавив. Уг хуулинд зарим

тодорхой бүтээгдэхүүнд онцлон анхаарч, ямар хугацаанд, яаж үйлдвэрлэхийг нарийн заажээ. Жишээ нь, суурь машин үйлдвэрлэлийн талаар: үйлдвэрлэлийн зардлыг 20 хувиар багасгаж, бүтээгдэхүүний хүчин чадлыг «Дэлхийн төвшинд хүргэх» зорилт тавин, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг төрөлжүүлэх шаардлагатайг тодорхойлсон байна. Энэ зорилтод хүрч чадахуйц техник, удирдлагын арга барилтай үйлдвэрийн газрыг Засгийн газраас хатуу журмын дагуу сонгон авч, Японы хөгжлийн банкнаас жилд 6,5 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай зээл олгох, шаардлагатай техник худалдан авахад гадаадын валютаар хангах, импортын татвараас чөлөөлөх зэрэг таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн бодлого явуулав.

Японы эдийн засгийн бодлогын бас нэг дэлгэрүүлүүштэй туршлага нь үйлдвэрлэлийн тодорхой зорилтоо хэрэгжүүлэхийн тулд дунд, бага оврын үйлдвэрийн газрыг өргөн ашигладаг явдал юм. Ялангуяа хөдөлмөрийн бүтээмж их, өвөрмөц хийц маяг, зохион байгуулалттай, нарийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, хувь хүний сонирхолд нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дунд, бага оврын үйлдвэрүүд зонхилж байгааг анхаарууштай. Тухайлбал, дунд, бага оврын эдгээр үйлдвэрийн газар хөлөг онгоц, суурь машин, цахим төхөөрөмж үйлдвэрлэгч том компаниудтай гэрээ байгуулан тодорхой нэрийн чанар сайтай төхөөрөмж, онц нарийн багаж, чухал сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэж байна. Дунд, жижиг оврын үйлдвэрийн ихэнх нь том пүүсүүдийнхээ хяналтанд Тэдгээрийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр ажилладаг. Эдгээрээс зарим нь техникийн төвшин, удирдлагын арга барил, ажилчдын мэргэжлийн ур чадвараар товойн гарснаас Сони, Хондагикэн коогёо, Кёосэра зэргийг нэрлэж болох юм. Дунд, жижиг үйлдвэрүүд нь аж ахуйн бүтцийн өөрчлөлтөд нааштай нөлөөлөхөөс гадна шинжлэх ухааны ололт, амжилтыг практикт нэвтрүүлэх, улмаар Японы эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсныг үгүйсгэх аргагүй юм.

Японы эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бас нэг чухал хүчин зүйл нь арвин мэдлэгтэй, үнэнч шударга, шургуу хөдөлмөрч ажиллах хүчнийг бэлтгэсэн явдал билээ. 1950-аад оноос эхлэн Японы үйлдвэрийн газруудад «ажил дээр нь сургалт явуулах» (on-the-job-training (OJT)) хэлбэр ихээхэн дэлгэрчээ. «OJT» нь ажилд анх орсон хүн энгийн хялбар үйлдлээс аваад хүнд хэцүү ажилд аажмаар шилжин, мэргэжлийн ур чадвар, албан тушаалаа дээшлүүлнэ гэсэн үг юм. Аливаа ажилчин албан тушаалд дэвшихийн өмнө уг ажлыг дороос нь дээш хүртэл хийж, ур чадвар, арга барил эзэмшиж, туршлагажсан байх ёстой ажээ. Энэхүү систем нь ажилчдын хөдөлмөрлөх эрмэлзэл, идэвх санаачилга, удирдах хүний авьяас, чадварыг үнэлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх чухал арга зам юм. Уг системийг хэрэгжүүлснээр олон жилийн сургалтын хөрөнгө хэмнэгдэхийн дээр хөдөлмөрийн талбарт сурч буй хүн ажлынхаа онцлог, арга барилыг илүү эзэмшиж, өөрийн хэр хэмжээндээ тохирсон туршлага хуримтлуулдаг байна.

Японы эдийн засгийн хөгжилд гадаад хүчин зүйл чухал нөлөөтэй байсан нь ойлгомжтой юм. Тэр тусмаа Япон улс түүхий эд, материалын бааз хомс учир гадаад орнуудтай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх шаардлага бүр ч их тулгарч байжээ.

Иймд Японд «гадаад худалдаанд тулгуурлах онол» (Боозеки риккокурон) дэлгэрсэн байна. Японы зарим эдийн засагчийн үзэж байгаагаар Мэйжигийн өөрчлөлтөөс (1868 он) өдий хүртэл 120 гаруй жил Японы эдийн засгийн хөгжлийн бодлого нь Засгийн газраас чиглүүлэн хэрэгжүүлсэн энэхүү гадаад худалдаанд тулгуурлаж байсан юм. Энэ нь эдийн засгийн хөгжлийн эхний үед шаардлагатай зүйлийг гадаадаас зайлшгүй авах, дараа нь түүнийг дотооддоо үйлдвэрлэн (импортыг орлох

бодлого), улмаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай болно гэсэн үг.

«Гадаад худалдаанд тулгуурлах бодлого»-ыг Засгийн газрын (ялангуяа Худалдаа, аж үйлдвэрийн яамны) шууд удирдлагаар хэрэгжүүлдэг байна. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий салбарыг хөгжүүлж, урьд өмнө гаднаас авч байсан бүтээгдэхүүнийг тэдгээр салбарт үйлдвэрлэн, гадагш гаргадаг болох зорилт тавьсан байна. Үүний тулд татварын бодлогыг тууштай явуулж, гадаад хөрөнгийг хязгаарлан, татварын бус хориг саадыг ашиглаж, Японы аж үйлдвэрийг хөгжүүлэх нөхцөл бүрэлдүүлэх шаардлагатай байв. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадваргүй дотоодын, үйлдвэрийн газрыг чухал тоног төхөөрөмж гаргахад татвараас чөлөөлөх, бага хүүтэй зээл олгох, хэрэглэж буй техникийн нь элэгдлийн шимтгэлийг өсгөх, шинэ мэдээллээр хангах зэрэг арга хэмжээ авч, «хөгжлөөр дорой үйлдвэрийн газрыг дэмжих бодлого баримталсан байна. Мөн Засгийн газраас гадаадын техник, технологи нэвтрүүлэхэд үйлдвэрийн газруудад адил тэгш боломж олгох бодлого явуулсны дүнд дотоодын тодорхой нэг салбарт үйлдвэр олноор байгуулагдаж, ямар нэгэн газрын монопольт байдал тогтохгүй, өрсөлдөөн ширүүсэж, бүтээгдэхүүний чанар, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх боломж бүрэлджээ.

Гадаад орны шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд маш богино хугацаанд нэвтрүүлж чадсан нь Японы гол онцлог юм. Жишээ нь, Шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд 1953-1973 онд Америкт 7,3 жил, ХБНГУ-д 5,6 жил шаардагдсан бол Японд дунджаар 3,5 жил зарцуулагдсан байна. Гэхдээ гаднын техник, технологийг ашиглахдаа Японы үндэсний болон эдийн засгийн өвөрмөц байдалт, уламжлалт ёс журам, япон хүний сэтгэхүйд тохируулж, зөвхөн тухайн техникийн талаар мэдээлэл цуглуулаад зогсохгүй түүний үнэ өртөг, үр ашиг зэргийг нарийн харгалзаж ирэв. Гадаадын шинжлэх ухаан, техникийн ололтыг судлах зорилгоор аж үйлдвэр хөгжсөн орнуудад олон тооны мэргэжилтнүүдээ явуулж байлаа. Жишээ нь, Америкийн үйлдвэрийн газруудын арга барилыг судлах зорилгоор 1955-1965 онд 660 удаа 6600 мэргэжилтэн АНУ-д явуулж, тэдгээр нь 40 мянган хуудас бүхий 166 дэвтэр тайлан бичиж Засгийн газартаа толилуулсныг шинжилж, дүгнэлт гарган хэрэгжүүлжээ. Гадаадын туршлагыг судлан тэвтрүүлэхдээ япончууд зөвхөн тухайн үеийн мэдээллийг хуримтлуулаад зогсоогүй холын ирээдүйг ч харж байдаг нь онцлог юм. Тухайлбал, гадаадын зах зээлийн цар хүрээ, хэрэглээний онцлог, цаашид тийшээ нэвтрэхэд юуг чухалчлах зэрэг асуудлыг анхаарч байсан нь одоо, Японы монополиуд дэлхийн зах зээлд зонхилж байгаагийн нэг нууц болов уу.

Улс орныхоо эдийн засгийн чухал салбарт гадаадын капиталын монопольт байр суурийг тогтоохгүйн тулд Засгийн газраас тодорхой арга хэмжээ авч ирсэн нь манай орны хувьд анхаарууштай мэт санагдана.

Гадаадын хөрөнгийг нэвтрүүлэхдээ Засгийн газрын нарийн хяналтанд туйлын болгоомжтой бодлого баримталж иржээ. Ингэхдээ Японы монополийн байр суурь хүчтэй байсан хар төмөрлөг, хөлөг онгоц үйлдвэрлэлийн салбарт гадаадын 100 хувийн хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн атал газар тариалан, ой, загасны аж ахуй, уул уурхайн салбарт гадаад хөрөнгө оруулалтыг хязгаарласан байна.

Ийнхүү улсынхаа эдийн засгийг хөгжүүлэхдээ гадаадын хөрөнгөнд тулгуурлан, тэдгээр орны хараат байдалд орох замаар биш, харин гадаад валютын хамгийн бага нөөцөөр тэдний шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлах замаар, дотоодын нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж, санхүү, зээл, худалдааны чадварлаг бодлого явуулсанд Японы эдийн засгийн эрчимт хөгжлийн гол онцлог оршино.